



ДЭЛХИЙН АГААРЫН СПОРТЫН ХОЛБОО

ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ

БҮЛЭГ 7 С – Класс О

ПАРАГЛАЙДИНГИЙН ЦЭГТ ГАЗАРДАХ ТӨРӨЛ

**2022 оны 5-р сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж буй
шинэчлэгдсэн хувилбар**

FEDERATION AERONAUTIQUE INTERNATIONALE**MSI - Avenue de Rhodanie 54 – CH-1007 Lausanne - Switzerland**

© Зохиогчийн эрх 2022

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэхүү баримт бичгийн зохиогчийн эрхийг Дэлхийн агаарын спортын холбоо (FAI) эзэмшдэг. FAI болон түүний гишүүдийн аль нэгийг төлөөлөн ажиллаж буй аливаа этгээд дараах нөхцлийн дагуу энэхүү баримт бичгийг хуулбарлах, хэвлэх, түгээх эрхтэй. Үүнд:

1. Баримт бичгийг зөвхөн мэдээллийн зорилгоор ашиглаж болох бөгөөд арилжааны зорилгоор ашиглахыг хориглоно.
2. Энэхүү баримт бичгийн хувь, эсвэл түүний аль нэг хэсгийг ашиглах бол энэхүү зохиогчийн эрхийн мэдэгдлийг заавал дурдах ёстой.
3. Тухайн улсын агаарын хууль, агаарын хөдөлгөөн, хяналтад хамаарах дүрэм журам нь ямар ч тохиолдолд мөрдөгдөх ёстой бөгөөд шаардлагатай тохиолдолд спортын аливаа дүрэм журмаас давуу эрхтэй байх ёстой.

Баримт бичигт дурдсан аливаа бүтээгдэхүүн, үйл явц, технологи нь FAI болон бусад аж ахуйн нэгжийн оюуны өмчийн бусад эрхийн объект байж болох ба энд лицензгүй гэдгийг анхаарна уу.

FAI-Н ОЛОН УЛСЫН СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭРХ

FAI-н Тэмцээний дүрмийг бүхэлд нь буюу хэсэгчлэн баримтлан зохион байгуулагдаж буй олон улсын спортын бүх арга хэмжээг FAI-н олон улсын тэмцээн гэж нэрлэдэг. Дээрх дүрмийн дагуу FAI нь олон улсын спортын арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой бүх эрхийг эзэмшиж, хянадаг. FAI-н гишүүдээс өөрийн улсын нутаг дэвсгэрийн хүрээнд болж буй олон улсын спортын арга хэмжээг FAI-ийн мэдэлд хамруулж, FAI-н спортын хуанлид бүртгүүлэхийг шаардана.

Ийм арга хэмжээнүүд дээр зохион байгуулагч нь бизнесийн аливаа үйл ажиллагааны эрхээ ашиглахыг хүсвэл FAI-тай урьдчилан тохиролцох ёстой. FAI-н эзэмшдэг, тохиролцсоны дагуу арга хэмжээний зохион байгуулагчдад шилжүүлж болох эрхүүд нь FAI-н арга хэмжээнүүд дээр сурталчилгаа хийх, үйл явдлын нэр, логог мерчандайзын зорилгоор ашиглах, аливаа дуу, дүрс, хөтөлбөр болон датаг цахим болон өөр хэлбэрээр, эсвэл бодит цаг хугацаанд дамжуулагдсан байдлаар ашиглах зэрэг багтана. Үүнд бас FAI-н олон улсын спортын арга хэмжээнд хэрэглэгдэх аливаа шүүлт, оноо, гүйцэтгэлийн үнэлгээ, мэдээллийн аливаа арга, системийг бүрдүүлж буй программ хангамж зэрэг цахим болон бусад материалыг ашиглах бүх эрхийг тусгайлан хамруулна.

FAI-н Агаарын спортын хороо тус бүр өөрсдийн хариуцсан төрөлдөө FAI-н гишүүд, эсвэл FAI-н гишүүнээс эрх олгосон бусад байгууллагуудтай FAI-н аливаа олон улсын спортын арга хэмжээнд (Дэлхийн агаарын спортын наадмаас бусад) эрхийг бүхэлд нь буюу хэсэгчлэн шилжүүлэх талаар хэлэлцээр хийж, эсвэл татгалзаж болно. Холбогдох Агаарын спортын хорооны дарга баталсны дараа зөвшөөрөл, эсвэл татгалзал дээр FAI-н удирдах албан тушаалтнууд гарын үсэг зурна.

Бичгээр тохиролцсон эсэхээс үл хамааран FAI-н спортын арга хэмжээг зохион байгуулах үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн аливаа хувь хүн, хуулийн этгээд нь дээр дурдсанчлан FAI-н өмчлөх эрхийг хүлээн зөвшөөрнө. Хэрэв эрх шилжүүлэх талаар бичгээр тохиролцоогүй бол FAI бүх эрхийг хадгална. Аливаа гэрээ хэлцэл, эрх шилжүүлэхээс үл хамааран FAI нь өөрийн архивын болон сурталчилгааны зорилгоор FAI-н аливаа спортын арга хэмжээний дуу, дүрс бичлэгийг үнэ төлбөргүй ашиглах эрхтэй. FAI нь аливаа арга хэмжээний бичлэгийг өөрийн зардлаар зохион байгуулах эрхтэй.

Редакторын тэмдэглэл:

Ханглайдинг болон параглайдингд зориулсан FAI-н Тэмцээний дүрэм нь Ерөнхий бүлэг ба Бүлэг 7-оос бүрдэнэ. Эргэлзээтэй тохиолдолд энэхүү Бүлэгт тусгагдсан тусгай дүрмийг хэрэгжүүлэхийн өмнө зарчмуудыг тогтоохын тулд Ерөнхий бүлгээс лавлана уу.

Ханглайдинг ба параглайдинг нь эрэгтэй, эмэгтэй аль аль нь оролцдог спорт юм. Энэ баримт бичигт "тэр", "түүний" гэсэн үгс нь өөрөөр заагаагүй бол хүйсийн аль алинд нь адилхан үйлчлэх зорилготой юм.

Үг хэллэг: "shall" ба "must" гэсэн үгсийг ашиглах нь заавал хэрэгжих ёстой гэсэн үг юм; "should" гэсэн хэрэглээ нь заавал биелүүлэх шаардлагагүй зөвлөмжийг илэрхийлдэг; "May" нь юуг зөвшөөрч болохыг, "will" нь юу болох гэж буйг заана. Ганц тоо олон тооны утга агуулж, мөн эсрэгээрээ байж ч болно.

ГАРЧИГ

1. ОРШИЛ БА НИСЛЭГИЙН ТОДОРХОЙЛОЛТ.....	6
2. ЭРХ ОЛГОЛТ, БҮРТГЭЛ.....	7
3. РАУНД	11
4. ГАЗАРДАХ ЦЭГ	17
5. ШҮҮЛТ	20
6. ТОРГУУЛЬ	23
7. ГОМДОЛ, ЭСЭРГҮҮЦЭЛ	24
8. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТАНДАРТ	25
9. ШҮҮГЧ	28

1. ОРШИЛ БА НИСЛЭГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Параглайдингийн цэгт газардах төрлөөр аварга шалгаруулах тэмцээнд зориулагдсан FAI-н Тэмцээний дүрмийн энэхүү 7C хэсэг нь "Бүлэг 7 - Нийтлэг"-ийн дэд хэсэг юм. Тиймээс энэхүү баримт бичгийг дараах бүлгүүдтэй хамт унших ёстой.

- Тэмцээний дүрэм – Ерөнхий бүлэг
- Бүлэг 7 – Нийтлэг
- Бүлэг 7 – Удирдамж ба загварууд
- Бүлэг 7D– Рекорд амжилтууд ба цол зэрэг

Энэхүү баримт бичиг нь үндсэндээ 1-р категорийн тэмцээний дүрмийг тодорхойлдог.

2-р категорийн хувьд Бүлэг 7- Нийтлэг, 12-р хэсэгт "1-р категорийн тэмцээний дүрэмд зохих хэмжээгээр үндэслэсэн байх ёстой" гэж заасан байдаг. Гэсэн хэдий ч зарим дүрмийг тодорхой зааж өгөх нь чухал юм. Тиймээс шаардлагатай бол энэ баримт бичиг нь тодорхой дэд бүлгүүдээрээ 2-р категорийн тэмцээний дүрмийг мөн тодорхойлдог.

1.1 Нислэгийн тодорхойлолт

Эдгээр тодорхойлолтууд нь Ерөнхий бүлэгт өгөгдсөн тодорхойлолтуудаас давуу эрхтэй хэрэглэгдэнэ. Параглайдингтай холбоотой нэмэлт тодорхойлолтыг Бүлэг 7A -Кросскантри-ээс олж болно.

1.1.1 Гараа үйлдэх/хөөрөх

Параглайдерын бүх хэсэг ба түүний нисгэгч/баг газраас тасрах цэг ба мөч.

1.1.2 Нислэг

Хөөрөх (1.1.1) цэгээс эхэлж буух (1.1.4.1) хүртэл параглайдерын хийсэн нислэг.

1.1.3 Чөлөөт нислэг

Параглайдерыг чирэх, зөөвөрлөх, эсвэл хөөргөхөд дэмжлэг үзүүлэх гадны ямар нэгэн тусалцаагүй байх үеийн нислэг.

1.1.4 Газардалт

1.1.4.1 Газардах

Нисгэгч, түүний тоног төхөөрөмж (хурдны систем, дөрөө, чирэх буулгаас бусад), эсвэл далавчны аль нэг хэсэг нь газарт, түүний дотор Автомат хэмжих төхөөрөмж болон дэвсгэр (хэрэв ашигласан бол) зэрэгт анхлан хүрэхэд нислэг дуусах мөч.

1.1.4.2 Газардах цэг

Нисгэгч газардахад газарт хүрсэн эхний цэг. Хөлийн ул эхлэн хүрсэн бол өсгий, улны хажуу, хуруу гэхчлэн тодорхойлох шаардлагатай. Бүтэн улаар хүрэлцэх тохиолдолд, эсвэл хоёр улаар зэрэг хүрсэн тохиолдолд тойргийн төвөөс хамгийн алслагдсан цэгийг газардах цэг гэж тооцох бөгөөд үүнийг хэмжиж, оноо өгнө.

1.1.4.3 Уналт

Уналт гэдэг нь нисгэгчийн биеийн аль нэг хэсэг (хөлөөс бусад), эсвэл тоног төхөөрөмж (хурдны систем, дөрөө, чирэх буулгаас бусад) далавч газарт буухаас өмнө, эсвэл нисгэгч тойргийн төв цэгээс 10 м-ийн гадна гарахаас өмнө газарт хүрснийг хэлнэ.

1.1.4.4 Цэг

Цэг гэдэг нь цэгт газардах тэмцээний үед нисгэгч буух зориулалттай тойрог юм. Энэ нь хавтгай, тэгш талбайд байрлах бөгөөд яг голд нь автомат хэмжих төхөөрөмж байрлуулан тойргийг тод томруун зурсан байна. 4.4-т тодорхой заасныг үзнэ үү.

1.1.4.5 Автомат хэмжих төхөөрөмж

5.4.2-т заасны дагуу электрон төхөөрөмж.

1.1.4.6 Цэгийн бүс

Цэг болон түүний эргэн тойрны бүс. Энд нэвтрэх эрхийг хязгаарлах бүсийг тодорхой болгон, тэмдэглэсэн байх ёстой. Энэ бүсэд салхины индикатор, шүүгчийн ширээ, бичлэг хийх төхөөрөмж, түргэн тусламжийн машин, үзэгчдийн хэсэг зэрэг байж болно. Цэгийн бүсийн талбай нь Автомат хэмжих төхөөрөмжөөс 30 м-ийн дотор, тэгш хавтгайд байх ёстой.

2. ЭРХ ОЛГОЛТ, БҮРТГЭЛ

2.1 Эрх олгох

Тэмцээний удирдамжид дараахь зүйлийг заана. Үүнд:

- Тэмцээнд оролцох нисгэгчдийн дээд тоо
- Нэг улсаас оролцож болох нисгэгчдийн дээд тоо.

2.1.1 Холимог аварга шалгаруулах тэмцээн

Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд эмэгтэйчүүдийн хувьд хамгийн багадаа нэг улсад 1 эрх олгоно. WPRS-д эрэмбэлэгдсэн 5 өөр улсын шилдэг 5 эмэгтэй нисгэгчийг улсынхаа шигшээ багт сонгогдоогүй байсан ч, НАС-ийн зөвшөөрлөөр оруулахыг зөвшөөрнө. Тивийн

аварга шалгаруулах тэмцээнд улс тус бүрээс эмэгтэйчүүдэд олгох эрхийн доод тоог тэмцээний удирдамжид зааж өгнө.

2.1.2 Зохион байгуулагч улс

Зохион байгуулагч улс нь холимог аваргын тэмцээнд эрэгтэйчүүдийг эмэгтэйчүүдийн эрхээр оруулж болохгүйг эс тооцвол WPRS-д топ эрэмбэ бүхий улстай адил тооны нисгэгч оролцуулах боломжтой.

2.2 Тэмцээнд оролцох эрх

2.2.1 Тэнцэх шалгуурууд

Тамирчин-нисгэгч бүр хүчинтэй нисгэгчийн үнэмлэх, эсвэл түүнтэй адилтгах ур чадварын гэрчилгээтэй байх ёстой. Энэ нь дараахь зүйлс байж болно. Үүнд:

- Олон улсын нисгэгчийн ур чадварыг тодорхойлох карт (IPPI), 4-р түвшний стандарт хангасан
- Хэрэв улс нь параглайдерын нисгэгчийн үнэмлэх олгодог бол энэ нь IPPI 4-тэй тэнцэх ёстой.

Хэрэв улс нь IPPI карт, эсвэл параглайдерын нисгэгчийн үнэмлэх олгодоггүй бол NAC нь зөвхөн шаардлага хангахуйц ур чадвартай нисгэгчдийг илгээх үүрэгтэй. Хангалттай ур чадваргүй аливаа нисгэгчийг Meet Director нисэхийг хориглож болно. Энэ тохиолдолд хураамж зэрэг зардлыг буцаан олгохгүй. WPRS чансааны эрэмбийг 1-р категорийн тэмцээнд оролцох нисгэгчийг сонгоход ашиглаж болно.

Чирэх төхөөрөмж: Нисгэгчид чирэх төхөөрөмжийн тусламжтайгаар гараа үйлдэх чадвартай гэдгээ нотлох баримт нотолгоотой байх ёстой. Энэ нь:

- NAC-ийн лиценз, эсвэл ийм гарааны мэргэшил, туршлагыг тодорхойлсон бичиг.
- Чирэх төхөөрөмжтэй гараагаар FAI-н зөвшөөрөлтэй тэмцээн зохион байгуулсан газраас гарын үсэг бүхий нислэгийн бүртгэл, эсвэл гэрчилгээ.
- Чирэх төхөөрөмжтэй гарааны сургалт курс төгссөн гэрчилгээ.

2.2.2 Туршлага

Уулнаас гараа үйлдэх:

Тэмцээнд оролцогчид огт салхигүй болон хүчтэй салхитай үед ч гараа үйлдэх чадвартай байх ёстой.

Чирэх төхөөрөмжийн тусламжтай гараа үйлдэх:

Нисгэгчид ийм гарааны хангалттай туршлага, ур чадвартай гэдгээ харуулахад бэлэн байх ёстой.

2.2.3. Шалгуураас чөлөөлөх

Чөлөөлөлт хүсэх нь шалгуурт тэнцэх өөр нэг арга биш юм. Зөвхөн онцгой тохиолдолд нисгэгчийг мэргэшлийн шаардлагаас чөлөөлж болно. Аливаа чөлөөлөлтийн хувьд нисгэгчийн олон улсын тэмцээнд оролцсон түүхийг нотлох баримтаар гарган, нисгэгчийн NAC өргөдөл гаргах ёстой. Тэмцээн эхлэхээс 60-аас доошгүй хоногийн өмнө CIVL-ийн Ерөнхийлөгч үүнийг хүлээн авах ёстой. Шалгуураас чөлөөлөгдсөн нисгэгчдийн жагсаалтыг зохион байгуулагчийн вэбсайтад нийтэлнэ. Нисгэгч шалгуураас чөлөөлөгдөн 1-р категорийн тэмцээнд оролцсон ч ердийн мэргэшлийн шалгуурыг хангаагүй бол дараагийн 1-р категорийн тэмцээнд оролцох эрхгүй болно.

2.2.4. CIVL-ийн Шалгаруулах хороо

Аварга шалгаруулах тэмцээн тус бүрээр CIVL-ийн даргыг оролцуулан Шалгаруулах хороог томилдог. Энэ нь даргатай тохиролцсоны дагуу CIVL-ээс томилогдсон гурван хүнээс бүрдэнэ. Шалгаруулах хороо нь:

- Чөлөөлөх хүсэлтийг хянан шалгах.
- Шаардлагатай бол нэмэлт мэдээлэл хүсэх
- Аюулгүй байдлын үүднээс шийдвэр гаргах

Дарга нь үзлэг шалгалтыг явуулж, NAC, зохион байгуулагч болон CIVL-ийн Ерөнхийлөгчид мэдээлдэг. Чөлөөлөх өргөдлийг шалгахын өмнө Шалгаруулах хороо нь чөлөөлөлт олгож болох нисгэгчдийн стандартыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Ийм стандарт нь тэмцээн бүрт ялгаатай байж болно.

Шалгаруулах хороо нь чөлөөлөх өргөдлийн маягтыг зохих ёсоор өөрчилж болно. CIVL-ийн ажилтан нь чөлөөлөх өргөдлийн маягт зохион байгуулагчийн вэбсайтад байгаа эсэхийг баталгаажуулна. Өргөдлийн маягт нь аварга шалгаруулах тэмцээнд тухайн нисгэгч оролцоход өөрийнх нь болон бусад оролцогчдын аюулгүй байдалд нөлөөлөхгүй гэж үзэж буйгаа баталгаажуулсан NAC-ийн дэмжлэг бүхий тодорхойлолтыг агуулсан байх ёстой. Нэмэлтээр авч үзэх материалыг хавсаргасан чөлөөлөх өргөдлийг хүлээн авч болох боловч шаардлагатай мэдээллийг орхигдуулсан бол татгалзаж болно.

2.3 Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүн

Хэрэв тэмцээн холимог биш бол (жишээ нь зөвхөн эрэгтэй, эсвэл зөвхөн эмэгтэй) багийн гишүүдийн тоог Тэмцээний удирдамжид зааж өгнө.

Хэрэв тэмцээн холимог бол багийн гишүүдийн тоог Тэмцээний удирдамжид зааж, хүйс тус бүрээс хамгийн багадаа нэг нисгэгч багтана.

2.4 Эрх хуваарилалт

WPRS-д хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн улсаас хамгийн сүүлд эрэмбэлэгдсэн улс хүртэл дарааллаар нь улс орнуудад эрхийг нэг нэгээр нь хуваарилдаг; Хэрэв дахиад эрх байгаа бол

дахиад дээрээсээ эхэлнэ. Хуваарилалтын үйл явц нь тэмцээн эхлэхээс 3-2 сарын өмнө явагддаг. Тэмцээний удирдамжид эцсийн хугацааг тодорхой зааж өгнө.

2 сарын хугацаа өнгөрсний дараа үлдсэн эрхүүдийг тэмцээн эхлэхээс 14 хоногийн өмнө хүртэл ерөнхий зарчмын дагуу хуваарилж болно. 14 хоногийн өмнөөс нисгэгчдийн эхний хурал/раунд хүртэлх хугацаанд зөвхөн нэг улсын дутуу нисгэгчийг тухайн улсын өөр нисгэгчээр сольж болно.

Энэ зорилгоор WPRS дахь улсын эрэмбэ нь аварга шалгаруулах тэмцээн эхлэхээс хуанлийн гурван сарын өмнөх эрэмбээр байна. Хожуу орлуулах шаардлага үүссэн тохиолдолд хуваарилагдсан тооноос илүү олон нисгэгчийг бүртгүүлэхийг НАС-д зөвлөдөг.

Холимог аварга шалгаруулах тэмцээнд эхлээд эмэгтэйчүүдэд, дараа нь эрэгтэйчүүдэд эрх хуваарилдаг. Эмэгтэйчүүдэд хуваарилагдсан эрхийг эрэгтэйчүүд нөхөх боломжгүй.

2.5 Бүртгэл

Тамирчин бүр дараахь зүйлийг үзүүлэх шаардлагатай.

- Паспорт.
- Тухайн улс нисгэгчийн үнэмлэх олгодог тохиолдолд хүчин төгөлдөр үнэмлэх.
- Параглайдер болон тоног төхөөрөмжийн нислэгт тэнцэх чадварын хангалттай нотолгоо.
- Даатгалд хамрагдсаныг баталгаажуулсан баримт.
- Шаардлагатай бол чирэх төхөөрөмжтэй гараа үйлдэх туршлагыг нотлох баримт.

Тамирчин бүр дараахь бичиг баримтанд гарын үсэг зурна.

- Хариуцлагаас чөлөөлөх тухай мэдэгдэл.
- Гэрчилгээтэй далавч болохыг баталсан мэдэгдэл.
- Бүртгэлийн маягт.

2.6 2-р категорийн тэмцээн

Дээрх дэд бүлгүүдээс 2-р категорийн тэмцээнд заавал дагаж мөрдөх шаардлагатай нь:

2.2

2.5

1-р категорийн сорилго болгон явуулж буй 2-р категорийн тэмцээнийг 1-р категорийн шаардлагын дагуу явуулах ёстой.

3. РАУНД

3.1 Хөөрөх, буух талбай

Тэмцээний вэбсайт дээр хөөрөх, буух гол газруудыг нарийн тодорхойлсон байх ёстой. Тэмцээний удирдамжид эдгээр газруудын GPS мэдээллийг өгөх ёстой.

Тэмцээний вэбсайт нь хамгийн багадаа:

- Уулнаас гараа хийх бол: Талбайн нэр, байршил, өндөр, хөөрөх/бэлтгэл хийх талбайн хэмжээ, буух талбай хүртэлх зай/өндөр, буух талбайгаас хөөрөх талбай хүрэхэд зарцуулах хамгийн бага хугацаа, нэмэлт/яаралтай буух газар, салхины чиглэл г.м.
- Чирэх төхөөрөмжтэй гараа хийх бол: Талбай/зурвасын нэр, байршил, хэмжээ, зохион байгуулалт, шаардлагатай чирэгч, эсвэл эргүүлгийн систем болон туслах тоног төхөөрөмжийн тоо/төрлийг жагсаах (хурдан салгах систем, тензиометр, сул холбоос). Хамгийн бага/ердийн чирэх өндөр, цэгийн бүсийн хэмжээ болон байршлын сонголтууд, салхины чиглэл. Нисгэгчид өөрсдийн хэрэгцээнд зориулж холбоос салгах хэрэгсэлтэй байх шаардлага. (Тоног төхөөрөмжийн шалгалт 8.1.5-ыг үзнэ үү)
- Боломжтой бол газрын зураг гэх мэт.

3.2 Раундын хэлбэр

3.2.1 Хөөрөх интервал

Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан суулт болон газардалтын үед нисгэгч хооронд хангалттай зай олгохын тулд нисгэгчдийг тодорхой хугацааны интервалаар хөөргөнө. Хөөрөх интервал нь нисгэгч хооронд 1.5 минут байх ёстой (Тэмцээний удирдамжид өөрөөр заагаагүй бол), гэхдээ Гарааны маршал нөхцөл байдалд тохируулан өөрчилж болно.

3.2.2 Нислэгийн дараалал

3.2.2.1 Нислэгийн дарааллыг тогтоох

Нисгэгчид дарааллын дагуу хөөрөх ёстой. Бүртгүүлэхдээ багийн ахлагч баг болон багийн гишүүдийнхээ нислэгийн дарааллыг баталгаажуулна. Багийн гишүүдэд 1, 2, 3 гэх мэт нислэгийн дарааллыг хуваарилна. Тэмцээн эхлэх үед багууд санамсаргүй байдлаар сугалж, багийн нислэгийн дарааллыг тодорхойлно. Дараа нь баг бүрийн бүх 1-ийн тоо эхлээд нисч, дараа нь 2, 3 гэх мэтээр ниснэ. Оролцогч бүрт мөн хувийн дугаар өгнө.

3.2.2.2 Урвуу дараалал

Meet Director эхний раундын дараа ямар ч раундыг урвуу дарааллаар явуулахаар шийдэж болно. Өөрөөр хэлбэл, бүх нисгэгчдэд зарласан тохиолдолд тэмцээний

одоогийн онооных нь урвуу дарааллаар хөөргөж болно. Харин нисгэгчид бэлтгэлээ хангах хангалттай хугацаатайгаар хөөрөх талбай руу явах боломжтой байх ёстой.

3.2.2.3 Төгсгөлийн раунд

Meet Director эцсийн раундыг зарлах үед (12-р раунд, эсвэл цаг хугацааны хязгаарлалтын улмаас Meet Director энэ нь тэмцээний эцсийн раунд болно гэж урьдчилан мэдэгдсэн бол өөр раунд ч байж болно) нисгэгчид авсан онооныхоо урвуу дарааллаар хөөрөх ёстой. Meet Director-ын зарласан төгсгөлийн раундыг дуусгаж чадахгүй бол урвуу дарааллаар явагдаагүй байсан ч өмнөх раунд нь эцсийн раунд болно.

3.2.3 Нислэгийн тоог боломжит дээд хэмжээнд хүргэх

Meet Director нь өдөрт хийх нислэгийн тоог аль болохоор олон байлгахыг эрмэлзэнэ. Тухайн өдөр раундыг дуусгах боломжгүй байсан ч шинэ раунд эхлүүлэхээр шийдэж болно.

3.2.4 Раунд хүчинтэйд тооцогдох

Тэмцээний раунд хүчинтэйд тооцогдохын тулд бүх оролцогчид тухайн раундад нэг нислэг хийх боломжийг олгоно. Аль ч раундын дүнг зөвхөн раунд дууссаны дараа (бүх тамирчин оноо авсан) ганцаарчилсан болон багийн оноогоор гаргана. Раундын дундуур завсарласан тохиолдолд тэмцээн зогссон газраасаа үргэлжлэн явагдана.

3.2.5 Гарааг эхлүүлэх бусад санал

Ижил зэрэглэлийн наад зах нь нэг тэмцээнд амжилттай хэрэгжсэн тохиолдолд шинэ гарааны системийг ашиглаж болно. Тэмцээн зохион байгуулах эрхийн төлөөх сонгон шалгаруулалтад оролцоходоо зохион байгуулах тал саналаа дэлгэрэнгүй танилцуулна.

3.2.6. Раундыг түр зогсоох

Хэрэв нэгээс олон хөөрөх арга, эсвэл талбай (хөөрөх ба газардах) ашиглаж байгаа бол дуусгах боломжгүй раундыг түр зогсоож болно. Өөр хөөрөх арга/талбай бүхий дараагийн раунд нь 1 дугаарын нисгэгчээс эхэлнэ. Цаг агаарын нөхцөл байдал боломжтой болвол түр зогсоосон раундыг нисч чадаагүй эхний нисгэгчээс эхлэн үргэлжлүүлнэ.

3.3 Раундад нисэх

Нисгэгчид аюулгүй ажиллагааны хурлын үеэр нислэгийн чиглэлийн талаар өгсөн аливаа зөвлөмжийг дагаж мөрдөх ёстой бөгөөд суулт хийж эхлэх хугацааг албаар сунжруулахгүй байх ёстой. Гэсэн хэдий ч тамирчид хоорондын зайг сайтар баримтлах шаардлагатай (3.3.6-г үзнэ үү), мөн газардах талбайд хүрэх боломжоо эрсдэлд оруулахгүйн тулд хангалттай өндөрт байхдаа цэг рүү суулт хийхээ тооцсон байх ёстой.

3.3.1 Туршин нислэг

Тэмцээний өдөр бүрийн нислэгийн эхэнд үнэлгээ хийх нислэгийг дор хаяж нэг удаа туршин нисгэгч хийнэ. Ингэхдээ цэгт хүрэх боломжтой, цаг агаарын нөхцөл тохиромжтой бөгөөд аюулгүй гэдгийг зохион байгуулагч болон тамирчдад харуулахын тулд цэг дээр буух

оролдлого хийнэ. Туршин нислэг хийж буй нисгэгч нь цэгт газардах нислэгийн туршлагатай байх ёстой бөгөөд тэмцээнд оролцож буй далавчуудын дийлэнхтэй ижил үзүүлэлт бүхий далавч ашиглах ёстой. Туршин нисгэгч нь тэмцээнд оролцож буй нисгэгч байж болохгүй.

3.3.2 Хөөрөх

Оролцогчид Гарааны маршал, эсвэл Meet Director-аас урьдчилан зөвшөөрөл аваагүй л бол оролцогчийн дугаарынхаа дагуу, нийтлэгдсэн дарааллаар нисэх ёстой. Ийм зөвшөөрлийг тухайлбал, нисгэгч давтан нислэг хийх шаардлагатай болсон тохиолдолд олгож болно. Гарааны маршал цаг агаарын нөхцөл байдал, эсвэл тухайн далавчны гүйцэтгэлээс хамааран хөөргөх дарааллыг түр зуур өөрчлөх ёстой гэж үзэж болно.

Гарааны маршал дуудсан үед тогтоосон нислэгийн дарааллаар нисэхэд бэлэн биш байгаа, эсвэл Гарааны маршалын зөвшөөрөлгүйгээр ниссэн оролцогчид тухайн раундад дээд онооны торгууль ногдуулна.

3.3.3 Раунд түр зогсоох буюу зогсоох

Нөхцөл байдал тохиромжгүй, эсвэл аюултай болсон тохиолдолд Meet Director гарааг түр зогсоож болно. Гараа хийх боломжтой цонх нээгдэх үед раунд нь зогссон газраасаа үргэлжилнэ. Нислэгийн нөхцөл байдалд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан, эсвэл нилээд хугацаагаар зогссоны дараа Meet Director болон Safety Director хэрэгтэй гэж үзвэл туршин нисгэгч эхлээд нисгэнэ.

3.3.4 Амжилтгүй гараа

Гараа амжилтгүй болох, эсвэл хөөрсний дараа аюулгүй байдалд асуудал үүсч, улмаар хөөрөх талбайд, эсвэл цэгээс хол буух тохиолдолд нисгэгч тухайн раундад дахин гараа хийх эрхтэй болно.

3.3.5 Гараа хийх чадваргүй байх

Хэрэв нисгэгч тэмцээний тогтоосон хязгаарт багтах салхи, цаг агаарын нөхцөлд аюулгүй гараа хийж чадахгүй байгаа бол түүнийг түр зогсоож, эсвэл бүрмөсөн тэмцээнээс хасч болно. Энэ шийдвэрийг Meet Director FAI-н төлөөлөгчтэй зөвлөлдсөний дараа гаргаж болно.

3.3.6 Нисгэгч хоорондын зай

Нисэж буй нисгэгч нар цэгт аюулгүй, саадгүй буухын тулд өндрөө зохицуулж, хоорондын зайг барина. Цэгийн тойрог дээр, бага өндөрт гүйцэж түрүүлэхийг хориглодог бөгөөд дээд онооны торгууль ногдуулдаг, мөн үүнийг аюултай нислэг гэж үзэж болно (Бүлэг 7С 6.3, эсвэл Нийтлэг бүлэг 7 – 9.1.2).

3.4 Цэгт газардах

Чирэх төхөөрөмжтэй гараа хийх: Тамирчинд цэгт газардах оролдлого хийх хангалттай боломж олгох ёстой. Гэсэн хэдий ч тамирчин цэг рүү орох суултаа зөв тооцоолон, цэгт шууд хүрэх хангалттай боломж бүхий өндөрт гармагцаа татлагыг суллаж хаях ёстой.

Уулнаас гараа хийх: Тамирчинд цэгт газардах оролдлого хийх хангалттай боломж олгох ёстой. Тэд нислэгийн үеэр газардах бүсэд шууд хүрэх боломжтой байх ёстой.

3.4.1 Газардахаар суулт хийж эхлэх

Тамирчин газардах талбай руу нүүрээ эгц харуулсан байдлаар суулт хийж эхэлвэл түүнийг цэг рүү чиглэсэн хандалтаа эхлүүлсэн гэж Ахлах шүүгч үзэх бөгөөд чиглэлд ямар нэгэн мэдэгдэхүйц өөрчлөлт орохгүй гэсэн хүлээлттэй байна. Энэ байрлалаас нисгэгчийн хийсэн цаашдын маневр нь дээрх ойлголтыг өөрчлөхгүй.

3.4.2 Цэг саадгүй байх

Тамирчин газардах талбай чиглэн суулт хийж, ойртох үед цэг нь саадгүй байх ёстой.

3.4.3 Цэг хаалттай дохио

Аюулгүй байдлын үүднээс цэгийг хаасан үед гарааг зогсоож, цэг дээр байгаа шүүгч дохионы улаан тугийг харагдахуйц даллаж, цахим дэвсгэрийг далдалж бүтээсэн байх ёстой. Энэхүү албан ёсны дохиог харуулах үед агаарт байгаа нисгэгчид цэгээс холдон газардана.

3.4.4 Салхины хурдны хязгаар

Тэмцээний нислэгийн сүүлийн 30 секундын хугацаанд цэг дээр хэмжсэн салхины зөвшөөрөгдөх дээд хурд нь 6 м/с бөгөөд газардах талбайд тусгайлан хамаарна. Хэрэв тухайн орон нутгийн нөхцөлд аюулгүй гэж үзвэл салхины дээд хурд 7 м/с хүртэл байж болох бөгөөд үүнийг Тэмцээний удирдамжид заасан байдаг.

Хэрэв дээд хязгаараас хэтэрсэн бол нисгэгчид дахин гараа хийхийг санал болгоно. Тэмцээний дараалсан хэд хэдэн нислэгийн үеэр газардах бүсэд салхины хурд тогтоосон хязгаараас давсан тохиолдолд Meet Director салхи хангалттай намжих хүртэл завсарлах шийдвэр гаргаж болно.

Салхины хурд нь газардах талбайд харагдах ёстой.

Нислэгийн аюулгүй байдлын асуудлаас бусад тохиолдолд агаар дахь салхи, гарааны талбай дахь салхийг хэмжиж тооцдоггүй.

3.4.5 Тойргийн гадна газардах

Цэгийн тойргийн гадна газардсан аливаа нисгэгч шүүгчдийн багт аль болох хурдан мэдэгдэх ёстой. Ингэж чадаагүй тохиолдолд давтан нислэг хийх хүсэлт тавих эрх үүсэхгүй.

3.4.6 Нислэгийн хил хязгаар

Тэмцээний зохион байгуулагч Тэмцээний удирдамж болон аюулгүй ажиллагааны хурал дээр хяналттай агаарын орон зай, эсвэл тэмцээний нислэгийг хориглосон, хязгаарласан бусад газрыг зааж өгнө. Ийм газруудыг хэвлэгдсэн газрын зураг дээр нарийн тэмдэглэнэ.

3.5 Давтан нислэг

Өрсөлдөж буй тамирчид маргаантай нислэгийн дараа дахин гараа хийх хүсэлт гаргах бол онооны хуудсанд гарын үсэг зурахаасаа өмнө цэг дээр байгаа Ерөнхий шүүгч/Ахлах шүүгчид хандана.

Тамирчин өөр хүнтэй ярилцалгүйгээр (ерөнхий болон ахлах шүүгчээс бусад) дахин гараа хийх хүсэлтээ Оноо бүртгэгчид хэлэх ёстой.

Ерөнхий, эсвэл ахлах шүүгч багтайгаа зөвлөлдөж, видео нотлох баримтыг үзэх боломжтой байхын тулд дахин нисэх хүсэлтийн талаар шийдвэр гаргахаа 15 минут хүртэл хойшлуулж болно.

Маргаантай нислэгийн оноо нь дахин нисэх эрх олгох үед цуцлагдана.

Дахин гараа хийх болсон шалтгааныг нисгэгчид болон олон нийтэд зарлана.

Давтан нислэгийг үргэлжилж байгаа болон дараагийн раундад аль болох хурдан хийлгэнэ.

Дахин нисэх эрх аваагүй нисгэгч оноонд гарын үсэг зурахаас татгалзвал энэ нь гомдол гэж тооцогдох бөгөөд гомдол гарсан цагийг бүртгэж, нисгэгчид мэдэгдэнэ. 7-р зүйл дэх Гомдол, эсэргүүцлийг үзнэ үү.

Дахин нисэх эрхийг зөвхөн дараах шалтгаанаар олгож болно. Үүнд:

3.5.1 Салхины хурд

Нисгэгч газардахаас 30 секундын өмнөөс эхлэн салхины хурд тогтоосон хэмжээнээс хэтэрсэн бол автоматаар дахин гараа хийхийг санал болгоно. Гэхдээ тамирчин авсан оноогоо хүлээн зөвшөөрөх, эсвэл дахин нисэх сонголтыг хийх боломжтой, мөн нэн даруй шийдвэр гаргах ёстой.

3.5.2 Цэг саадтай байсан

Тамирчин газардах талбай чиглэн суулт хийж, ойртох үед цэг саадтай байсан бол. Ийм тохиолдолд нисгэгч тодорхой дохио өгч, цэгийн бүсээс гарч явах ба цэг рүү буух оролдлого хийх ёсгүй.

3.5.3 Шүүгчид санал нийлэхгүй байх

Шүүгчид ямар нэгэн шалтгаанаар, тэр дундаа автомат хэмжих төхөөрөмж ажиллаагүй байх зэрэг шалтгаанаар зөв оноог хэлж чадахгүй бол.

3.5.4 Аюулгүй байдлын шалтгаанууд

Оролцогч аюулгүй байдлын үүднээс нислэгийн төлөвлөгөөгөө өөрчилсөн бол. Энэ тохиолдолд нисгэгч тодорхой дохио өгөн, цэгийн бүсээс гарч явах ёстой бөгөөд цэг рүү буух оролдлого хийхгүй.

3.5.5 Анхаарал сарниулах зүйл гарсан

Оролцогч цэг рүү суулт хийх явцад илт нөлөөлсөн гадны анхаарал сарниулах аливаа зүйл байсан бол. Энэ тохиолдолд нисгэгч тодорхой дохио өгөн, цэгийн бүсээс гарч явах ёстой бөгөөд цэг рүү буух оролдлого хийхгүй. Хэрэв нисгэгч цэгийн бүсээс аюулгүй гарч нисэх боломжгүй хэт нам өндөрт байвал анхаарал сарниулсан зүйл байгааг дохио зангаагаар тодорхой зааж өгөх ёстой.

3.5.6 Шүүгчийн үзэмж

Техникийн асуудал, эсвэл хэвийн бус нөхцөл байдал (жишээ нь, хуй салхи) үүссэн бол шүүгчдийн үзэмжээр дахин гараа хийх зөвшөөрөл өгч болно. Энэ нь мөн далавч хэрэгслийн гэмтэл, доголдол (жишээ нь, жолооны строп тасарсан, эсвэл нислэгийн үеэр том хумигдалт үүссэн) байж болох бөгөөд энэ нь нисгэгч нислэгийн өмнөх үзлэгээ муу хийснээс болоогүй бол, эсвэл их хэмжээний живэлт үүссэнээс нисгэгч цэгт хүрч чадахгүй байх, эсвэл хангалтгүй өндөртэй орж ирсний улмаас зөв суулт хийх боломжгүй нөхцөл үүссэн зэрэг. Нисгэгч цэг рүү орох оролдлого хийгээгүй тохиолдолд дахин нисэх зөвшөөрөл олгож болно.

3.6 Видео баримт

3.6.1 Видео бичлэг хийх

Тэмцээний зохион байгуулагч нь суурин болон хөдөлгөөнт камераар цэгт газардах үеийн дүрс бичлэг хийх ажлыг хариуцна. Ийм албан ёсны видео бичлэгийг нэмэлт нотлох баримт болгон ашигладаг бөгөөд дараахь хүмүүс ашиглаж болно. Үүнд:

- Ерөнхий болон ахлах шүүгч
- Хяналтын зөвлөл (jury) эсэргүүцлийн асуудлыг шийдвэрлэхдээ хянан үзэхээр шийдсэн бол.

Видео нотлох баримтыг тамирчинд үзүүлэх, эсвэл өгөх үүрэг хүлээхгүй.

3.6.2 Видео бичлэгт тавигдах шаардлага

Видео камер нь нисгэгчийн газарт анх хүрсэн цэгийг тодорхой харуулахын тулд цэгийн тойрогт хангалттай ойрхон бөгөөд доогуур тусгалтай байрласан байна.

3.6.3 Сонирхогчдын видео бичлэг

Тэмцээний зохион байгуулагч нь гомдол, эсэргүүцэл шийдэх үед шүүгчдийн баг сонирхогчийн видео бичлэгийг хэрхэн ашиглах тухай журмыг Тэмцээний удирдамжид зааж өгнө.

3.6.4 Хяналтын зөвлөл (Jury)-ийн шийдвэр

Хяналтын зөвлөл шийдвэр гаргахдаа видео бичлэгийг нэмэлт нотлох баримт болгон авч болно. Харин ингэж авсан нь дараагийн эсэргүүцэл шийдэх жишиг тогтоохгүй. Хэрэв зохион байгуулагчид тухайн буултын видео бичлэг байхгүй, эсвэл тодорхой харагдахгүй

байвал энэ нь дахин нисэх эрх олгох үндэслэл болохгүй. Эсэргүүцэж буй нисгэгч гэрчийн мэдүүлэгт найдах ёстой.

3.7 Амралтын өдөр

Meet Director нь дөрвөн өдөр дараалан тэмцээний нислэгүүд хийгдсэний дараа (хэрэв тэмцээний сүүлийн өдөр биш бөгөөд доод тал нь зургаан раунд хийгдээгүй бол) бүтэн, эсвэл хагас өдрийг амралтын өдөр гэж зарлаж болно. Зөвхөн дээрх нөхцөл хангагдсан бол урьдчилан төлөвлөсөн амралтын бүтэн, эсвэл хагас өдрийг тогтооно. Цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас товлосон амралтын өдрийг өөрчилж болно. Амралтын өдрийг өмнөх өдрийнх нь орой зарлана.

Амралтын өдрүүдэд зохион байгуулагчаас нисгэгчид, багийн ахлагч, FAI-н ажилтнуудад ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээлгэх ёсгүй.

3.8 2-р категорийн тэмцээн

Дээрх дэд бүлгүүдээс 2-р категорийн тэмцээнд заавал мөрдөгдөх ёстой нь:

3.2.1

3.2.4

3.3 (бүгд) Тайлбар: 3.3.5 Meet Director Гарааны маршал ба/эсвэл Ерөнхий шүүгчтэй зөвлөлдөнө.

3.4 (бүгд)

3.5 (бүгд)

3.6 (3.6.4 үгүй)

4. ГАЗАРДАХ ЦЭГ

4.1 Байршил – Уулнаас гараатай үед

Цэг нь аль ч талаас буух боломжтой байрлалд байх ёстой. Аюулгүй байдлын хорооны зөвлөмжийг сонссоны дараа Ерөнхий шүүгч, Meet Director хоёр цэгийн байршлыг тогтооно. Буух цэгийн байршлыг раунд хооронд шилжүүлж болох боловч раунд явагдаж байх үед болохгүй.

Цэгийг тогтоох удирдамж: Төлөвлөсөн зай ба өндрийн зөрүү (гарааны талбай - цэг) хоорондын харьцаа хамгийн ихдээ 5:1 гулсалтын харьцаатай байна. Салхины хүч, эсвэл чиглэл өөрчлөгдвөл Meet Director-ийн шийдвэрээр гарааны цэгийг хэзээ ч шилжүүлж болно.

4.2 Байршил – Чирэх төхөөрөмжтэй гарааны үед

Нисгэгчид тухайн тэмцээний удирдамжид заасан дээд хурд хүртэлх салхинд, татлагыг хаясны дараа цэгт хялбар хүрэх боломжтой байх ёстой. Салхины хүч, чиглэл өөрчлөгдвөл Meet Director-ийн шийдвэрээр гарааны цэгийг хэзээ ч шилжүүлж болно. Буух цэгийн байршлыг раунд хооронд шилжүүлж болох боловч раунд явагдаж байх үед болохгүй. Мөн 3.2.6 Раунд түр зогсоох-ыг үзнэ үү.

4.3 Автомат хэмжих төхөөрөмж

Цэгийн тойргийн голд тод өнгийн 2 см диаметр бүхий голчтой автомат төхөөрөмжийг байрлуулна. Автомат төхөөрөмжийн төв цэгээс дискний ирмэг хүртэл хамгийн багадаа 15 см байх бөгөөд 1 см тутамд хэмжих чадвартай байх ёстой. Төхөөрөмжийг хатуу суурь хавтан дээр хөдөлгөөнгүй бөгөөд аль болох тэгш суурилуулсан байх ёстой. Голч төвийн диаметр тухайн тэмцээний туршид адил байх ёстой . Автомат хэмжих төхөөрөмжийг Ерөнхий шүүгч батална.

4.4 Цэгийн тойрог

1.1.4.4-ийг үзнэ үү. Цэгийн тойрог нь тамирчин оноогоо хэмжүүлэхийн тулд буухыг зорьж буй талбай юм. Энэ нь төв хэсэгтээ автомат хэмжих төхөөрөмж бүхий тод зурсан тойрогтой, бараг тэгш хавтгай талбай байх ёстой.

Тодорхой тэмдэглэгдсэн тойрог нь гол төвөөс хэмжсэнээр 1 м ба 2 м радиустай байх ёстой. Нэмэлт тойрог нь 10 м-ийн радиустай байх ёстой бөгөөд энэ нь уналтыг зөвшөөрөхгүй хэсгийг илэрхийлж байгаа юм. (5.4.1-р хэсгийг үзнэ үү)

Энэ тойрог нь нислэгийн үеэр тамирчдад цэгийн байршлыг тодорхой харуулах зорилготой бөгөөд оноо авах зориулалттай биш юм.

4.4.1 Цэгийн тойргийн хэмжээ

1-р категорийн тэмцээний тойргийн радиус нь 2 метр байна.

2-р категорийн тэмцээнд тойргийн радиус 2, 5, эсвэл 10 метр байж болно. Үүнийг Тэмцээний удирдамжид тусгаж, зохих ёсоор тэмдэглэсэн байх ёстой.

4.4.2 Цэгийг байгуулах

Цэгийн тойрог нь нисгэгчийн буух цэгийг тодорхойлох боломж олгохуйц материалаар (өвс, элс, дэвсгэр г.м) хийгдсэн байх ёстой. Цэгийн байршил нь буух талбайтай бүхэлдээ ижил өндөрт байх ёстой, өөрөөр хэлбэл овгор товгор, эсвэл хонхор газар байж болохгүй.

Цаг агаар чийглэг, хүйтэн жавар, мөстэй байж болох тул гулгахгүй материалаар хийгдсэн байх ёстой.

Цэгийн тойрог болон орчмын бүс нь тэгш, буух цэгийг тэмдэглэхэд саад болохуйц өндөр өвс, ургамалгүй байх ёстой. Өвсийг богино буюу 50 мм хэмжээнд тэгшилж хадах нь зүйтэй.

Ерөнхий шүүгч цэгийн гадаргуу болон бүтцийг батална.

4.4.3 Нэвтрэх хязгаарлалт

Ерөнхий/ахлах шүүгч нь цэгийн тойрог орчмын бүсэд зөвхөн үүрэг гүйцэтгэж буй албаны багийн нэвтэрч болох талбайн хязгаарыг тогтооно. Энэ нь тойргийн гадна захаас 10 м-ээс багагүй радиустай байх ёстой. Талбайн хилийг зохих ёсоор тодорхойлж, тэмдэглэнэ.

4.5 Салхины чиг заагч

Маш сайн харагдацтай голдуныг цэгийн тойргийн бүсэд, газрын түвшнээс 5м-ээс багагүй өндөрт байрлуулна. Голдун нь хамгийн багадаа 2.5 м урттай байх ба 6 м/с хурдтай салхинд хөндлөн байрлалд заах зориулалттай, чөлөөтэй намирах хөдөлгөөнд нь саад болох зүйл байх ёсгүй. Тод хоёр өнгөөс бүтсэн, агаараас тод ялгарч харагдахаар, бараан өнгө нь нарийссан үзүүрт, цайвар өнгө нь ишний талд байхаар байрлуулна.

Салхины хурд 1 м/с-ээс бага үед салхины чиглэлийг заах дор хаяж 4 индикатор (дарцаг, тууз гэх мэт) байх ёстой. Тэдгээр нь автомат хэмжих төхөөрөмжөөс ойролцоогоор 15 м-ийн зайд, талбайн квадрант бүрт байрлах ёстой. Тэдгээр нь хамгийн багадаа 1,5 м урттай байх ёстой бөгөөд үзүүр нь газраас хөндий байхаар бэхлэгдсэн байна. Тэдгээр нь цэгийн бүсээс ялгарахуйц тод өнгөтэй байх ёстой бөгөөд агаараас тод харагдах ёстой.

4.6 Салхины хурд бүртгэгч

Мэдрэгчтэй салхи хэмжигчийг газрын түвшнээс дээш 5-7 м-ийн хооронд байрлуулж, цэгээс 50 м-ийн радиус дотор хэмжинэ. Салхи хэмжих автомат төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд шүүгчид газрын түвшнээс 5 м-ээс багагүй өндөрт байрлах өөр цахилгаан болон механик багаж хэрэгслийг ашиглаж болно.

4.7 2-р категорийн тэмцээн

Дараахь дэд бүлгүүдийг 2-р категорийн тэмцээнд заавал хэрэглэнэ. Үүнд:

4.1

4.2

4.3

4.4. Тайлбар: 2-р категорийн тэмцээний тойргийн радиус нь 10 м хүртэл байж болно. Тодорхой тэмдэглэгдсэн тойргууд нь цэгийн төвөөс 1 м, 2 м, 5 м радиустай байх ёстой.

4.4.1

4.4.2

4.5

5. ШҮҮЛТ

5.1 Тэмцээн хүчинтэй болох

АШТэмцээн хүчинтэй болохын тулд дор хаяж гурван раундын оноо бүтэн авагдсан байх ёстой.

2-р категорийн тэмцээн хүчинтэй болоход дор хаяж нэг раундын оноо бүтэн авагдсан байх ёстой.

Нийт раундын тоо 12-оос илүүгүй байна. Хэрэв 12-оос бага раунд хийхээр төлөвлөсөн бол Тэмцээний удирдамжид заана.

5.2 Оноо өгөх

Тэмцээний оноог өгөхөд CIVL-ээс батлагдсан онооны системийг ашиглана.

Тамирчинд өгсөн оноог сантиметрээр илэрхийлж, хамгийн ойрын сантиметр хүртэл бүхэлчилнэ. Оноог “лайв” бүртгэх онлайн бистем байвал сайн, гэхдээ буух талбайд үзэгчдэд зориулан харуулах боломжтой байх ёстой.

5.3 Оноог бүртгэх

5.3.1 DNF, DSQ, Absent

Тухайн раундад нисээгүй нисгэгчийг онооны хуудсан дээр DNF гэж тэмдэглэж, хамгийн дээд оноог өгнө.

Өвчин, эсвэл ослын улмаас тэмцээнээ орхисон нисгэгчийг Absent гэж тэмдэглэн, дараачийн нисээгүй бүх раундад дээд оноо өгнө.

Тухайн раундад нисэх эрхээ хасуулсан нисгэгчийг онооны хуудсан дээр DSQ тэмдэглэж, хамгийн дээд оноог өгнө.

Тухайн тэмцээнд оролцох эрхээ хасуулсан нисгэгчийг өрсөлдөж буйд тооцохгүй бөгөөд оноо өгөхгүй.

5.3.2 Онооны хуудас

Онооны хуудас нь "Урьдчилсан" болон "Албан ёсны" гэсэн тэмдэглэгээтэй байх ба дүнг гаргасан огноо, цаг, мөн Ерөнхий шүүгчийн гарын үсэгтэй байна.

5.4 Оноо өгөх арга

5.4.1 Тамирчны оноо

Тамирчны газардсан цэг (газарт хүрсэн эхний цэг) болон тойргийн төв цэг хоёрын хоорондын зайг сантиметрээр хэмжин оноог өгнө. Хэрэв буусан цэг нь дискний яг голд бол оноо нь 0 см байна.

Хэрэв тамирчин тойргоос гадуур газардвал оноог хэмжихээр тогтоосон тойргийн радиус болох дээд оноог авна.

Тамирчин гол төв цэгээс 10 м-ийн радиус дотор хөл дээрээ буух ёстой. Хэрэв тамирчин буухдаа унавал тойргийн гадна буусантай адил дээд оноо авна.

Хэрэв тамирчны хөлийн анхлан газар хүрсэн хэсгийг (өсгий, хажуу, хуруу г.м) тодорхойлох боломжгүй байдлаар газардвал хөлийн мөрний хамгийн алслагдсан цэгийг хэмжинэ.

Хэрэв тамирчин хоёр хөлөөрөө зэрэг газардсан бол төвөөс хол тавигдсан хөлийн мөрний хамгийн алсын цэгийг хэмжинэ.

5.4.2 Автомат хэмжих төхөөрөмж

Хамгийн багадаа 15 см хүртэлх оноог автомат хэмжих төхөөрөмжөөр (AMD) хэмжинэ. Тамирчнаас автомат хэмжих төхөөрөмжид тодорхой хэмжээний даралт үүсгэснээр оноог бүртгэх боломжийг олгоно. Автомат хэмжих төхөөрөмж гэмтэлтэй, эсвэл дахин тохиргоо хийгдээгүй, эсвэл даралт хангалтгүйгээс хэмжилт хийгдээгүй тохиолдолд газарт анхлан хүрсэн цэгийг зөв тогтоож чадсан гэдэгтээ шүүгчид итгэлтэй, тууштай байвал гар аргаар хэмжиж болно.

Автомат хэмжих төхөөрөмжийн гадна талд нисгэгчийн анхлан хүрсэн цэгийг илүү тод харуулахын тулд дискний гадуур илүү том хяналтын дэвсгэр тавихыг Зохион байгуулагчид зөвлөж байна.

5.4.3 Ганцаарчилсан оноо

Ганцаарчилсан оноо нь тухайн оролцогчийн авсан бүх онооны нийлбэр байна. Тав ба түүнээс дээш хүчинтэй раунд хийсэн тохиолдолд хамгийн муу нэг оноо хасагдана. Албан ёсоор бүртгүүлсэн тамирчин бүр хүчин төгөлдөр, оноо авсан өрсөлдөгч хэвээр үлдэхийн тулд тэмцээний үеэр дор хаяж нэг удаа нисэх ёстой.

5.4.3.1 Өсвөрийн тэмцээний чансаа

Өсвөрийн тэмцээний чансааг зөвхөн өсвөр насны нисгэгчдийг нийт авсан онооных нь дагуу жагсаан гаргадаг. Жич: Өсвөрийн чансааг гаргахдаа 26 хүртэлх насны нисгэгчдийн дүнг нэгтгэн тооцно. Насыг нисгэгчийн төрсөн өдрөөр нь тухайн хуанлийн жилээр тогтоодог.

5.4.4 Багийн оноо

ДАШТэмцээнд улсын багийн оноог тухайн улсын багийн шилдэг гурван нисгэгчийн нийлбэр оноогоор тооцно. Хэрэв аль нэг улс гурваас цөөн оролцогчтой бол раунд бүрт дутуу хүн тус бүрээр хамгийн дээд оноог багт өгнө.

Тивийн АШТэмцээнд тухайн улсын багийн оноо нь тухайн улсын багийн хамгийн шилдэг Ү нисгэгчдийн нийлбэр оноо байх ба Тэмцээний удирдамжид Ү-г заасан байдаг (2.3.). Ү нь $(X+1)/2$ гэсэн үг бөгөөд X нь багт байж болох нисгэгчдийн хамгийн их тоо юм.

Багийн оноог тооцохдоо хамгийн муу оноог хасна гэсэн зүйл байхгүй.

5.4.5 Оноо тэнцэх, хайн хагалах

5.4.5.1 Багууд

Тэмцээний төгсгөлд эхний гурван багийн оноо тэнцсэн тохиолдолд, нөхцөл байдал боломжтой бол, тухайн баг тус бүрийн бүх гишүүд нэмэлт нислэг үйлдэж, үр дүнгээр нь тухайн улсын багийн оноог тооцно (5.4.4). Гараа хийх боломжит цонх хэзээ дуусахыг тэмцээний өдрийн өглөө багийн ахлагч нарын хурал дээр зарлана.

Meet Director-ын тооцоолсноор хугацаа хангалтгүй тохиолдолд баг бүрээс нэр дэвшсэн нэг гишүүн нислэг үйлдэнэ.

Хэрэв цаг агаарын нөхцөл байдал, цаг хугацааны хязгаарлалтаас шалтгаалж хайн хагалах нислэгийг бүрэн хийж чадахгүй болвол багийн оноог бүрдүүлсэн нисгэгчид нь раунд бүрт хамгийн олон удаа 0см оноо авсан багийг ялагчаар зарлана. Хэрэв 0-ийн тоо ижил байвал 1см-ийн оноо хамгийн олон авсан, дараа нь 2см-ийн оноо гэх мэтчилэн тооцно. Хэрэв хайн хэвээр байвал шигшээ багийн бүх нисгэгчдээс хамгийн их 0см оноо авсан багийг шалгаруулна. Хэрэв 0-ийн тоо ижил байвал 1см-ийн онооны хамгийн их тоо, дараа нь 2см-ийн оноо гэх мэтээр тооцно.

5.4.5.2 Ганцаарчилсан

Эхний гурван байрны хувьд хайн үүссэн тохиолдолд тэнцсэн хоёр нь (эсвэл бүгд) нэмэлт нислэг хийнэ. Хэрэв цаг агаарын нөхцөл байдал, эсвэл цагийн хязгаарлалтаас шалтгаалан хайн хагалах нислэг хийх боломжгүй бол хамгийн олон 0 см оноо авсан нисгэгчийг ялагчаар зарлана. Хэрэв 0 см онооны тоо нь ижил байвал 1 см-ийн оноо олонтой нь, дараа нь 2см оноо гэх мэтээр тооцно.

5.4.6 Оноог баталгаажуулах

Раунд дууссаны дараа Оноо бүртгэгч нь тухайн раундын оноог аль болох хурдан (огноо, цагтай) “Урьдчилсан” гэсэн тэмдэглэгээтэйгээр мэдээллийн самбарт тавина. Оноотой холбоотой аливаа гомдол, эсэргүүцлийг заасан хугацаанд гаргана. 7.1, 7.2.2-ыг хар. Оноог байршуулсны дараа заасан хугацаанд эсэргүүцэл гараагүй тохиолдолд гарын үсэг зураагүй оноог шийдвэрлэсэн гомдол гэж үзнэ. Энэ хугацаанд оноог албан ёсоор зарлана.

5.5 Гэмтсэн нисгэгчид туслах

Гэмтсэн нисгэгчид туслахын тулд газардсан, эсвэл нислэгээ хязгаарласан нисгэгч энэ үйлдлээсээ болж хохирох ёсгүй.

Гэсэн хэдий ч, дахин нисэх эрх олгох нь Meet Director-ын шийдвэр байх бөгөөд тэрээр шийдвэр гаргахаасаа өмнө бүх нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай. Аюул осолд орсон нисгэгчидтэй холбоотой журмыг Нийтлэг бүлэг, 7-11-р хэсгээс үзнэ үү.

5.6 2-р категорийн тэмцээн

Дээрх дэд бүлгүүдээс 2-р категорийн тэмцээнд заавал мөрдөх ёстой нь:

5.3.1

5.4.1

5.4.2

5.4.3

6. ТОРГУУЛЬ

6.1 Зөвшөөрөгдөх торгууль

Meet Director нь FAI-н Тэмцээний дүрэм, эсвэл тухайн тэмцээний удирдамжид заасан аливаа дүрмийг зөрчсөн, эсхүл дагаж мөрдөөгүй нисгэгчид торгууль ногдуулна. Торгуулийн хэмжээ нь тухайн зөрчилд тохируулан сануулга өгөхөөс эхлээд эрх хасах хүртэл байж болно. Торгууль оногдуулсан тухай мэдээллийн самбарт бичгээр нийтэлнэ.

Энэхүү баримт бичиг, эсвэл тухайн тэмцээний журамд өөрөөр заагаагүй бол Meet Director-аас оногдуулсан торгууль нь түүний шийдвэр байх бөгөөд дараахь 3-ын аль нэг нь байж болно.

- Сануулга
- Тухайн раундад хамгийн дээд оноо өгөх
- Эрх хасах

Цэгийн бүсэд аюултай нислэг хийж, спортын бус үйлдэл гаргасан тохиолдолд Ерөнхий шүүгч сануулга хэлбэрээр торгууль ногдуулж болно.

6.2 Торгууль хэрэглэх

Meet Director торгууль хэрэглэхдээ тууштай байж, нэг буюу хэд хэдэн тамирчин ижил зөрчлийг давтан үйлдсэн тохиолдолд торгуулийг нэмэгдүүлж болно. Нисгэгч нэг нислэгээр дүрэм журмыг нэгээс олон удаа зөрчиж, тухайн зөрчил бүрт шаталсан торгууль байгаа тохиолдолд Meet Director нэгээс олон торгууль ногдуулж болно.

Цэгийн бүсэд аюултай ниссэн, спортын бус үйлдэл гаргасан тохиолдолд сануулах хэлбэрээр шийтгэл оногдуулахдаа Ерөнхий шүүгч тууштай хандана.

6.3 Торгуулийн төрлүүд

- Аюултай эсвэл түрэмгий* нисэх

Эхний удаа: сануулга

Хоёрдахь удаа: тухайн раундад хамгийн дээд оноо

Гурав дахь удаа: эрх хасах

- Станцаар зааварчилга өгөх

Эхний удаа: тухайн раундад хамгийн их оноо.

Хоёрдахь удаа: эрх хасах.

- Албаны хүмүүстэй зүй бус харьцах, спортын нэр хүндийг унагах

Эхний удаа: сануулга

Хоёрдахь удаа: эрх хасах

* Үүнд акро төрлийн нислэг багтаж болох ба юуг зөвшөөрч болох/болохгүй талаар Meet Director, эсвэл Ерөнхий шүүгч танилцуулах ёстой.

6.4 2-р категорийн тэмцээн

2-р категорийн тэмцээнд дээрх дэд бүлгүүдээс заавал мөрдөгдөх ёстой нь:

6.1

6.2

6.3

7. ГОМДОЛ, ЭСЭРГҮҮЦЭЛ

Тэмцээнийг зохион байгуулагч нь видео бичлэг болон бусад нотлох баримтыг тэмцээн дууссанаас хойш 90-ээс доошгүй хоногийн турш, эсвэл давж заалдах гомдлыг шийдвэрлэх хүртэл хадгалж, архивлана (Ерөнхий бүлэг, 6-г үзнэ үү).

7.1 Гомдол

Багийн ахлагч нь Ерөнхий шүүгчид, бичгээр, англи хэлээр гомдол гаргаж, оноог засч залруулах хүсэлт тавьж болно. Урьдчилсан дүнг нийтэлснээс хойш хоёр цагийн дотор үүнийг хийх ёстой.

Шүүлтээс бусад асуудалтай холбоотой гомдлыг Meet Director-г гаргаж болно.

Хэрэв урьдчилсан оноог нар жаргаснаас хойш 2 цагийн дараа, маргааш өглөөний 6.00 цагаас өмнө нийтэлсэн бол гомдол гаргах эцсийн хугацаа нь өглөөний 8.00 цаг байна.

Тэмцээний сүүлчийн шатанд урьдчилсан дүнг нийтэлснээс хойш нэг цагийн дотор гомдол гаргаж болно. Өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэнэ. Тухайн тэмцээний удирдамжид гомдол гаргах хугацааг өөрөөр зааж болно.

7.2 Эсэргүүцэл

Гомдол гаргагч нь үр дүнд сэтгэл хангалуун бус байвал багийн ахлагч нь Meet Director-т бичгээр, англи хэлээр, тусгай маягтыг ашиглан эсэргүүцэл бичиж болно.

Ерөнхий шүүгч гомдлын хариуг мэдэгдсэнээс хойш 2 цагийн дотор эсэргүүцэл бичнэ. Тэмцээний сүүлийн хоёр раундад гомдлын хариуг Ерөнхий шүүгч мэдэгдсэнээс хойш 1 цагийн дотор эсэргүүцэл бичнэ. Meet Director хүлээн авсан цагийг тэмдэглэж, эсэргүүцлийг нэн даруй Хяналтын зөвлөлийн даргад шилжүүлнэ.

Эсэргүүцлийн хураамжийн хэмжээг тэмцээний удирдамжид заана. Энэ нь 50 ам. доллар, эсвэл 50 еврогоос ихгүй байна. Эсэргүүцлийг тамирчны талд шийдсэн тохиолдолд хураамжийг буцаан олгоно. Тэмцээний удирдамжид эсэргүүцлийн эцсийн хугацааг өөрөөр зааж болно.

7.3 2-р категорийн тэмцээн

2-р категорийн тэмцээнд дээрх дэд бүлгүүдийг заавал мөрдөх ёстой:

7.1

7.2 S7 Нийтлэг бүлэг, 12.7-г үзнэ үү.

8. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТАНДАРТ

8.1 Параглайдер

8.1.1 Ангилал

Зөвхөн EN гэрчилгээтэй параглайдераар нисэхийг зөвшөөрнө.

8.1.2 Нислэгт тэнцэх чадварын стандарт болон хязгаарлалт

Параглайдер бүр өөрийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, нисэх зөвшөөрөл, үйлдвэрлэгчээс тогтоосон хязгаарлалтын хүрээнд ниснэ.

Акробат нислэгийн маневр хийхийг хориглоно.

8.1.3 Нислэгт тэнцэх чадварыг нотлох баримт

Бүртгүүлсний дараа нисгэгч Баталгаажсан Глайдерын Гэрчилгээнд гарын үсэг зурах шаардлагатай. Удирдамж болон загваруудыг үзнэ үү.

8.1.4 Баталгаажсан параглайдер

Эхний өдөр ашигласан бүрэлдэхүүн хэсгүүд болон параглайдерыг тэмцээний туршид ашиглана.

Параглайдерыг өөрийнх нь гэрчилгээний стандартаас өөр болгохуйц байдлаар өөрчлөхийг зөвшөөрөхгүй. Зайлшгүй шаардлагатай засвар хийх болсон тохиолдолд энэ дүрмийг хөнгөвчлөн үзэж болно.

Аливаа томоохон гэмтлийг Meet Director-т цаг алдалгүй мэдэгдсэний дараа засч болно. Аливаа солих эд анги нь анхны техникийн үзүүлэлттэй яг тохирч байх ёстой.

Нисгэгчээс үл хамаарах гэмтэл, үрэгдэл, хулгайд алдах зэрэг шалтгааны улмаас параглайдерыг түр, эсвэл бүрмөсөн солих зөвшөөрлийг Meet Director өгсөн бол түүнийг яг ижил, эсвэл ижил марк, загварын параглайдераар сольж болно.

8.1.5 Нислэгт тэнцэх чадварыг шалгах

Зохион байгуулагч, түүний дотор Аюулгүй байдлын захирал нь тэмцээний үеэр нислэгт тэнцэх чадварыг шалгах ёстой. Зохион байгуулагчид болон албаны хүмүүс тэмцээний аль ч үед ямар ч далавч болон бусад хэрэгслийг, түүний дотор суудал, нөөц шүхэр, дуулга, чирэх төхөөрөмж, гутал зэргийг шалгах, шаардлагатай бол аюулгүй байдал, эсвэл стандартад үл нийцэх шалтгаанаар газардуулах эрхтэй.

Ангилал, нислэгт тэнцэх чадварын стандартыг дагаж мөрдөөгүй тохиолдолд энэ дүрэм болон тэмцээний удирдамжид заасан бусад торгуулийг зохион байгуулагч хэрэглэнэ. Өрсөлдөгч бүх нисгэгчид зохион байгуулагч болон албаны хүмүүстэй хамтран ажиллах ёстой.

8.2 Радио холбооны хэрэгсэл

Зохион байгуулагчаас тогтоож өгсөн аюулгүй байдлын долгион дээр хүлээн авч, дамжуулах чадвартай радио холбооны хэрэгсэл авч явахыг нисгэгчдээс шаардана. Нислэгийн явцад тухайн долгион дээр тохируулж, ашиглах ёстой. Долгионыг тэмцээний удирдамжид заасан байна.

Дуугаар идэвхжүүлдэг микрофон (VOX) ашиглахыг хатуу хориглоно. Өрсөлдөгчдийг цэгт буулгахын тулд радио холбооны хэрэгсэл, гар утас, эсвэл бусад харилцааны хэрэгслийг ашиглахыг (аюулгүй байдлын шалтгаанаас бусад тохиолдолд) хатуу хориглоно.

8.3 Бусад тоног төхөөрөмж

8.3.1 Суудал

Бүх нисгэгчид 2017 он болон түүнээс хойшхи LTF09, EN1651 стандартын дагуу шалгаж, тохируулга хийгдсэн, нурууны хамгаалалт бүхий суудалтай нисэх ёстой.

8.3.2 Дуулга

Бүх нисгэгчид нислэгийн үеэр EN966 (HPG), EN1077-A ба –B (Цасны спорт), ASTM 2040 (Цасны спорт) эсвэл Snell RS-98 стандартын гэрчилгээтэй дуулга өмсөх ёстой.

8.3.3 Нөөц шүхэр

Нисгэгчид ашиглах боломжтой нөөц (ослын, аврах) шүхэртэй байх ёстой. Нисгэгчид нөөц шүхрийн зөвшөөрөгдсөн жингийн дээд хэмжээн дотор байгаа эсэхийг шалгана.

8.3.4 Гутал

Тамирчны гутал нь дараахь шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- Гутал нь аюулгүй хөөрөх, буухад тохиромжтой байх ёстой.
- Гуталд автомат хэмжих төхөөрөмжийг (AMD) гэмтээхүйц байдлаар нэмэлт өөрчлөлт хийж болохгүй.
- Гуталд хийсэн аливаа өөрчлөлт нь дараах шаардлагыг хангасан байна.

о Материал:

- Резин, эсвэл түүнтэй адилтгах шинж чанартай материалаар хийсэн байна.
- Металл, керамик, эсвэл хатуу хуванцраар хийсэн бол зөвшөөрөхгүй.
- Материалын хатуулгийг Shore Durometer-ээр хэмжихэд дээд тал нь “70” байх ёстой (А түвшин).*
- Материал нь автомат хэмжих төхөөрөмжийн дэвсгэр дээр ул мөр үлдээхгүй.

о Хэмжээ:

- Өөрчлөлтийн өргөн буюу диаметр нь хамгийн багадаа 15.0 мм байна.
- Өөрчлөлтийн ирмэгүүдийн булангийн радиус(ii) нь хамгийн багадаа 2.0 мм байна. (Ямар ч хурц ирмэг байх ёсгүй)
- Бөмбөгөр хэлбэрийн өөрчлөлтийн радиус нь хамгийн багадаа 8.0 мм байх ёстой (улан дээрх бондгорыг тодорхойлох радиус).
- Өөрчлөлт нь гутлын ул, эсвэл өсгийн гадаргуугаас хамгийн ихдээ 8.0 мм товойж гарсан байх ёстой. (гүн)

* Энэ нь дунд зэргийн резинтэй тэнцэнэ. Жишээ нь: Харандааны дээд талд байрлах баллуур шиг "дунд зэргийн зөөлөн" резин нь "40" орчим, автомашины дугуй шиг "дунд зэргийн хатуу" резин нь "70" байна.

2-р категорийн тэмцээн

2-р категорийн тэмцээнд дээрх дэд бүлгүүдийг заавал мөрдөх ёстой. Үүнд:

8.1.4.

8.1.5

8.2.

8.3.1

8.3.2.

8.3.3

8.3.4

9. ШҮҮГЧ

Шүүгчид нь FAI-н албаны хүмүүс бөгөөд тамирчдын гүйцэтгэлийг ажиглах, тэмдэглэх, хэмжих чадвар эзэмшсэн байна. Дараах зүйлийг CIVL-ийн Шүүгчийн дүрэмтэй хамт уншиж, хэрэглэх ёстой.

9.1 Тавигдах шаардлагууд

Ерөнхий

- Шүүгчид шударга, бие даасан шийдвэр гаргах чадвартай байх ёстой.
- Шүүгчид нь Тэмцээний дүрмийн Ерөнхий бүлэг, Бүлэг 7С, шүүж буй тэмцээнийхээ удирдамж, Шүүгчийн дүрэм, FAI болон CIVL-ээс гаргасан бусад холбогдох баримт бичгүүдийн талаар дэлгэрэнгүй мэдлэгтэй байх ёстой.
- Тэмцээний ерөнхий болон ахлах шүүгчид нь параглайдингийн аюулгүй байдлын талаар анхан шатны мэдлэгтэй байх ёстой.
- Англи хэл нь CIVL-ийн албан ёсны хэл юм.

о 1-р категорийн тэмцээнд бүх шүүгч нар англи хэлээр ярьдаг байх.

о 2-р категорийн тэмцээнүүдэд нисгэгчдийн 50-иас дээш хувь нь тухайн тэмцээнийг зохион байгуулж буй улсаас бус, өөр улсаас ирсэн бол ерөнхий шүүгч, ахлах шүүгч нар англи хэлээр ярьдаг байна. Нисгэгчдийн 50-иас бага хувь нь өөр улсаас ирсэн бол англи хэлний орчуулагчийг үргэлж бэлэн байлгана.

9.2 Зөвшөөрөл

Шүүгчид бол FAI-н албаны хүмүүс.

Шүүгчид өөрсдийн НАС, эсвэл эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй байх бөгөөд энэ нь 2-р категорийн тэмцээн уралдаанд мөн хамаарна. НАС-ууд тухайн улсынхаа үндэсний шүүгчдийн бүртгэлийг хөтөлж, яваандаа Cat 1 тэмцээний шүүгчээр хүлээн зөвшөөрөгдөхүйц нэр дэвшигчдийн нэрийг CIVL-д ирүүлнэ.

9.2.1 1-р категорийн тэмцээн

CIVL нь Cat 1-ийн батлагдсан шүүгчдийн бүртгэлийг шинэчилж, вэбсайтаа тогтмол нийтэлнэ. (9.6-г үзнэ үү)

9.2.2 2-р категорийн тэмцээн

Үндэсний шүүгчид шүүж болно. Рекорд амжилтыг бүртгэх болон цол, зэргээ ахиулах оролдлого хийх үед 1-р зэргийн дор хаяж нэг шүүгч байх ёстой.

9.3 Баг

Шүүгчдийн баг дор хаяж дараах тооны шүүгчээс бүрдэнэ. Үүнд:

1-р категорийн тэмцээн

Ерөнхий шүүгч 1
Ахлах шүүгч 1
Цэгийн шүүгч 5
Нөөц шүүгч 3
Нийт 10

- Ерөнхий шүүгч нь зохион байгуулагч улсаас байж болохгүй.
- Ерөнхий болон ахлах шүүгчид 2 өөр улсаас байна.
- Шүүгчдийн баг нь 3 өөр улсаас бүрдсэн байна.

1-р категорийн тэмцээний сорилго тэмцээн

Ерөнхий шүүгч 1
Ахлах шүүгч 1
Цэгийн шүүгч 5
Нөөц шүүгч 2
нийт 9

- Ерөнхий болон ахлах шүүгчид 2 өөр улсаас байна.
- Тэмцээний ерөнхий болон ахлах шүүгч нар нь дараах 1-р зэрэглэлийн тэмцээнийг шүүх хүмүүс байхыг зөвлөнө.
- Шүүгчдийн баг 2 өөр улсаас бүрдсэн байна.

2-р категорийн тэмцээн

Ерөнхий шүүгч 1

Ахлах шүүгч 1 (гэхдээ доороос үзнэ үү)

Цэгийн шүүгч 3

Нөөц шүүгч 1

Нийт 6

- Нисгэгчдийн 50 ба түүнээс дээш хувь нь зохион байгуулагчаас өөр улсынх байвал шүүгчийн баг 2 өөр улсаас бүрдсэн байна.
- Тэмцээнд 50-иас доош нисгэгч оролцох ёстой бол тэмцээний ерөнхий шүүгч, ахлах шүүгч нь нэг хүн байж болно.

9.4 Нэр дэвшүүлэх

Шүүгчдийн багийн гишүүдийг сонгох, томилохтой холбоотой шалгуурыг CIVL-ийн Параглайдингийн цэгт газардах төрдийн шүүгчийн дүрмийг үзнэ үү.

9.5 Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага

9.5.1 Автомат хэмжих төхөөрөмж

5.4.2-ыг үзнэ үү.

9.5.2 Бусад хэмжих ба онооны төхөөрөмж

Зохион байгуулагчид Бүлэг 7- Удирдамж ба загварууд хэсгээс Шүүлтийн бүх хэрэгслийн жагсаалтыг харна уу.

9.5.3 Хувцас

Бүх шүүгчид тод харагдах өнгийн хувцас (хантааз, подволк гэх мэт) өмсөх ёстой. 1-р категорийн тэмцээнд зохион байгуулагчаас цаг агаарын нөхцөл байдалд тохируулан, агаар нэвтрүүлдэг хувцас олгоно. Хувцас нь хамгийн багадаа FAI/CIVL логотой байх ба ар талд нь "ШҮҮГЧ" гэсэн бичигтэй байх ёстой.

9.5.4 Харилцаа холбооны хэрэгсэл

Зохион байгуулагч нь Meet Director, Ерөнхий шүүгч, Ахлах шүүгч, Гарааны маршал, FAI-н төлөөлөгч, Жюри хоорондоо шууд харилцах боломж олгохуйц холбооны хэрэгслүүдээр хангана.

9.5.5 Албаны багийн түр байр

Зохион байгуулагч нь шүүгчид болон бусад туслах ажилтнуудыг түр байрлах байр, хоолоор хангах ёстой.

9.6 Шүүгчдийн бүртгэл

CIVL 1-р зэргийн шүүгчдийн жагсаалтыг хөтөлдөг. CIVL-ийн шүүгчдийн семинарт оролцож байгаа болон 1-р категорийн тэмцээн, эсвэл тэдний өмнөх сорилго тэмцээний шүүгчээр томилогдсон бүх шүүгчдийг уг жагсаалтад бүртгэнэ. CIVL-ийн шүүгчдийн семинарыг зохион байгуулагчид нь тэдний мэдээллийг цуглуулж, CIVL-д илгээх үүрэгтэй.

НАС нь өөрсдийн Cat 2 (болон үндэсний) шүүгчдийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй.